



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/479

Номгон

Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг
хэлэлцэх зөвлөл томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/550 дугаар тушаалаар батлагдсан Эхийн эндэгдлийг тооцох, бүртгэх, хэлэлцэх журмын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг хэлэлцэх зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

-Эрүүл мэндийн газрын дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга;

-Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл, халдварын асуудал хариуцсан эмч;

-Эрүүл мэндийн газрын анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан эмч;

-Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч;

-Дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч;

-Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч;

Нарийн бичгийн дарга:

-Эх, нярайн тусламж үйлчилгээ хариуцсан эмч

2.Зөвлөл нь Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам батлах тухай" А/550 дугаар тушаалыг хэрэгжүүлж, тайланг жил бүр Засаг даргын дэргэдэх Удирдлагын багт танилцуулахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311239